

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/31/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас: 261740 Цахим хаяг: baasantsendt@audit.gov.mn Аудитор: Г.Тэлмүүн Утас: 261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал	13
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	22
4. АУДИТЫН ТАЙЛАН	31
4.1 Ерөнхий зүйл.....	31
4.2 Материаллаг байдал.....	31
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	31
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	31
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	33
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	34
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	35
5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил:	36
5.2 Түүврийн байгууллагын аудитаар илэрсэн алдаа, зөрчил:	37
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	39
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	39
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	40
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	42
Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл.....	43

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЗГ	Засгийн газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТХС	Зам Тээвэр Хөгжлийн сайд
МУ	Монгол Улсын
МУБШУС	Монгол Улсын Боловсрол Шинжлэх ухааны сайд
МУТШСБЭЗХС	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТБОНӨБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ҮШУТС	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан
ШУА	Шинжлэх ухааны академи
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БЗЭБуй	Борлуулах зорилгоор эзэмшиж буй



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР ТАНАА

2026.04.24 № 1135
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 665,776.5 сая төгрөгөөр давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Монгол улсын хөгжлийн банк нь тайлант онд 33 зээлийн үндсэн болон хүү, алдангийн төлбөрийн 2,331,849.3 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 338,084.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Монгол улсын хөгжлийн банк нь өмчлөхөөс бусад хөрөнгө болон борлуулах зориулалттай нийт 141,131.1 сая хөрөнгийн үлдэгдлийг жилийн эцсийн хөрөнгийн тооллогод хамруулаагүй;

- Ди Би Эм лизинг ХХК нь тайлант онд 18 санхүүгийн түрээсийн үндсэн болон хүү, алдангийн төлбөрийн 40,995.8 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 5 түрээсийн 16,878.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Монгол улсын хөгжлийн банк нь банк, санхүүгийн байгууллагад байршуулсан 11,091.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй;
- Эдийн засаг, хөгжлийн яам нь Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар гадны зочин төлөөлөгч хүлээн авах зардлын төсөв баталж, 15 хуулийн этгээдтэй хоол болон танхимын түрээсийн үйлчилгээний гэрээ байгуулан анхан шатны баримтаар нотлогдохгүй нийт 280.6 сая төгрөгийн гүйлгээг санхүүжүүлсэн;
- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар нь байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалын жагсаалтад гэрээт шинжээч, судлаач, зөвлөхийн орон тоо батлан, гэрээт ажилтантай шууд хөдөлмөрийн гэрээ байгуулж, төрийн албаны цалингийн шатлалын дагуу 419.2 сая төгрөгийг цалингийн сангаас цалинжуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.3 дах заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Монгол Улсын Хөгжлийн банк" ХХК-ийн төрийн эзэмшлийн эрхийг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр тогтоосон.

Тайлант онд Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2, 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 29 дүгээр зүйлийн 29.1.8 дахь заалт, 29.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны "Аудитын сэдэв батлах тухай" 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллага "Монгол Улсын Хөгжлийн банк" ХХК болон түүний охин компани болох Ди Би Эм ассет менежмент ХХК, Ди Би Эм лизинг ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитыг нийцлийн аудиттай хослуулан гүйцэтгэсэн. Аудитаар "Монгол Улсын Хөгжлийн банк" ХХК-ийн 1,546,671.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь аудитын "Сөрөг" дүгнэлт өгөх үндэслэл болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,918,046.5 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/1396 тоот албан бичгээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 447.6 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 4,195,412.8 сая төгрөгөөр тус тус бууруулж төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 27 арга хэмжээг

санхүүжүүлэхээр 275,007.2 сая төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг судалгаа, тооцоололд үндэслэхгүйгээр бодитой төлөвлөхгүй байна.

Монгол улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор 2024 онд шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсвийн багцдаа багтаан зохицуулалт хийх замаар, цаашид үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад даалгасан. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны урсгал зардлын төсөв, зарцуулах эрхийг тус газрын захиралд шилжүүлж, нийт 2,228.0 сая төгрөгийн санхүүжилтийн татаас олгосон боловч тус байгууллага нь өөрсдийн үндсэн үйл ажиллагаанаас орлого олохгүй байгаа нь цаашид улсын төсвөөс хараат болж, өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах чадамжгүй болох эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,154,937,955.1	2,789,494,350.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	461,606,262.8	1,196,227,026.0
33	АВЛАГА	351,478,037.8	340,958,929.3
34	УРЬДЧИЛГАА	11,360,702.5	10,151,034.9
35	БАРАА МАТЕРИАЛ	6,000,120.6	5,482,250.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,324,492,831.4	1,236,675,110.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,537,595,135.8	1,491,144,548.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,325,758,767.1	1,216,168,527.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	211,836,368.7	274,976,021.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,692,533,090.9	4,280,638,899.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,895,809,543.9	2,793,140,544.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	168,791,383.9	222,798,662.5
41200	Богино хугацаат зээлийн өглөг	107,972,671.9	58,660,000.0
41300	Өглөг	60,738,412.0	164,138,662.5
41400	Урьдчилж орсон орлого	80,300.0	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,727,018,159.9	2,570,341,882.4
42100	Урт хугацаат үнэт цаас	1,354,247,799.8	2,362,728,414.1
42200	Урт хугацаат зээл	372,770,360.1	207,613,468.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,796,723,547.1	1,487,498,354.2
51	Засгийн газрын хувь оролцоо	1,796,723,547.1	1,487,498,354.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	55,273,469.0	54,690,008.5
51200	Хуримтлагдсан үр дүн	480,201,203.4	163,201,922.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	44,948,534.1	52,720,878.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,692,533,090.9	4,280,638,899.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	385,292,223.9	392,613,703.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	216,293,407.5	392,613,703.2
120	Нийтлэг татварын бус орлого	209,789,159.7	235,165,559.1
122	Тусламжийн орлого	6,504,247.8	157,448,144.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,998,816.4	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	340,449,469.4	604,700,628.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	340,449,469.4	604,700,628.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,047,833.3	153,218,562.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,501,745.4	87,330,687.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,471,451.0	10,725,435.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,410,187.4	2,883,072.3
2104	Хангамж, бараа материалын зардал	3,003,052.1	3,660,130.7
2105	Нормативт зардал	1,226,106.1	1,583,006.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,969,313.0	1,199,650.3
2107	Томилолт, зочны зардал	5,237,591.0	5,336,709.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,252,927.7	27,551,059.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,975,459.7	12,948,810.3
211	ХҮҮ	115,463,600.1	401,421,133.1
212	ТАТААС	238,442.2	2,227,981.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,699,593.8	47,832,951.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	44,842,754.5	(212,086,925.0)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	74,422,298.5	42,480,302.8

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	133,169,124.7	96,818,497.8
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(58,746,826.2)	(54,338,195.0)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(13,904,071.7)	(266,425,120.0)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	560,911,083.4	455,423,091.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	391,646,418.5	455,423,091.2
120	Нийтлэг татварын бус орлого	385,142,170.7	297,643,174.7
122	Тусламжийн орлого	6,504,247.8	157,779,916.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	169,264,664.9	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	423,088,729.9	408,134,729.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,088,729.9	408,134,729.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	227,374,655.3	129,469,392.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,632,628.3	85,388,776.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,350,025.7	10,241,169.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,209,604.0	2,879,936.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,886,463.4	2,744,338.3
2105	Нормативт зардал	1,097,022.8	1,230,028.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,165,634.2	1,411,036.9
2107	Томилолт, зочны зардал	5,450,135.1	5,292,646.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,342,711.7	17,188,733.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,240,430.1	3,092,726.3
211	ХҮҮ	168,469,106.8	227,560,165.0
212	ТАТААС	239,997.7	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,004,970.2	51,105,171.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	137,822,353.5	47,288,362.2
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	12,406,114.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	103,148,936.9	111,897,610.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	103,148,936.9	111,897,610.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(103,148,936.9)	(99,491,496.6)
14	Бусад эх үүсвэр	952,639,967.6	1,321,260,721.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	630,981,723.4	534,436,823.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	321,658,244.2	786,823,897.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	356,331,660.8	734,620,763.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	105,274,602.1	461,606,262.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	461,606,262.8	1,196,227,026.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,966,285.9	426,445.7	1,282,296,362.4	1,290,689,094.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	47,307,183.1	18,359,812.0	35,947,267.2	101,614,262.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	55,273,469.0	18,786,257.7	1,318,243,629.6	1,392,303,356.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(114,361.3)	-	(114,361.3)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	(11,696,002.5)	-	(11,696,002.5)
Өмчид гарсан өөрчлөлт	1,216,300,340.6	37,972,640.2	(824,138,354.4)	430,134,626.4
Тайлант үеийн үр дүн	-	-	(13,904,071.7)	(13,904,071.7)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,271,573,809.6	44,948,534.1	480,201,203.4	1,796,723,547.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(50,561,115.7)	(50,561,115.7)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,271,573,809.6	44,948,534.1	429,640,087.7	1,746,162,431.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(4,868.2)	-	(4,868.2)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	7,777,212.7	-	7,777,212.7
Өмчид гарсан өөрчлөлт	1,743.6	-	(13,045.2)	(11,301.6)
Тайлант үеийн үр дүн	-	-	(266,425,120.0)	(266,425,120.0)
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,271,575,553.2	52,720,878.6	163,201,922.5	1,487,498,354.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	259,487,226,000.00	134,831,750,893.20	124,655,475,106.80	52.0
Татварын бус орлого	259,487,226,000.00	134,831,750,893.20	124,655,475,106.80	52.0
Нийтлэг татварын бус орлого	2,388,298,800.00	2,334,745,717.80	53,553,082.20	97.8
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	2,388,298,800.00	2,334,745,717.80	53,553,082.20	97.8
Тусламжийн орлого	257,098,927,200.00	132,497,005,175.30	124,601,922,024.70	51.5
Төсвөөс санхүүжих	257,098,927,200.00	132,497,005,175.30	124,601,922,024.70	51.5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	259,487,226,000.00	134,470,622,429.20	125,016,603,570.80	51.8
УРСГАЛ ЗАРДАЛ	112,972,126,000.00	98,060,377,732.20	14,911,748,267.80	86.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	106,181,064,500.00	94,455,958,840.70	11,725,105,659.30	89.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,525,128,900.00	66,456,591,926.00	5,068,536,974.00	92.9
Үндсэн цалин	40,732,266,800.00	41,212,831,503.60	(480,564,703.60)	101.2
Нэмэгдэл	18,285,504,300.00	12,881,965,134.30	5,403,539,165.70	70.4
Унаа хоолны хөнгөлөлт	7,854,207,200.00	7,867,527,456.70	(13,320,256.70)	100.2
Урамшуулал	4,634,759,900.00	4,433,057,594.90	201,702,305.10	95.6
Гэрээт ажлын хөлс	18,390,700.00	61,210,236.50	(42,819,536.50)	332.8

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,010,235,300.00	7,916,441,122.50	1,093,794,177.50	87.9
Тэтгэврийн даатгал	6,093,436,700.00	5,386,324,483.70	707,112,216.30	88.4
Тэтгэмжийн даатгал	729,350,200.00	658,462,708.50	70,887,491.50	90.3
ҮОМШӨ-ний даатгал	368,616,500.00	359,863,128.10	8,753,371.90	97.6
Ажилгүйдлийн даатгал	363,692,500.00	303,241,404.00	60,451,096.00	83.4
Эрүүл мэндийн даатгал	1,455,139,400.00	1,208,549,398.30	246,590,001.70	83.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,552,444,000.00	2,270,442,880.90	282,001,119.10	89.0
Гэрэл, цахилгаан	944,297,200.00	920,717,897.90	23,579,302.10	97.5
Түлш, халаалт	627,454,900.00	484,537,555.30	142,917,344.70	77.2
Цэвэр, бохир ус	207,368,700.00	158,856,706.20	48,511,993.80	76.6
Байрны түрээс	773,323,200.00	706,330,721.50	66,992,478.50	91.3
Хангамж, бараа материалын зардал	1,470,985,900.00	1,231,370,784.80	239,615,115.20	83.7
Бичиг хэрэг	217,512,700.00	167,878,159.00	49,634,541.00	77.2
Тээвэр, шатахуун	114,472,700.00	80,479,916.00	33,992,784.00	70.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	299,118,200.00	250,872,684.10	48,245,515.90	83.9
Ном, хэвлэл	457,734,700.00	445,215,735.30	12,518,964.70	97.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,478,600.00	17,370,830.00	26,107,770.00	40.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	338,669,000.00	269,553,460.40	69,115,539.60	79.6
Нормативт зардал	283,205,600.00	240,179,628.40	43,025,971.60	84.8
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	252,651,300.00	214,297,728.40	38,353,571.60	84.8
Хоол, хүнс	2,084,600.00	682,300.00	1,402,300.00	32.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,469,700.00	25,199,600.00	3,270,100.00	88.5
Эд хогшил, урсгал засварын зардал	3,859,015,400.00	3,401,427,627.60	457,587,772.40	88.1
Багаж, техник, хэрэгсэл	2,917,677,000.00	2,530,647,016.50	387,029,983.50	86.7
Тавилга	49,420,000.00	49,365,665.00	54,335.00	99.9
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	174,906,800.00	132,778,310.90	42,128,489.10	75.9
Урсгал засвар	717,011,600.00	688,636,635.10	28,374,964.90	96.0
Томилолт, зочны зардал	3,478,100,900.00	2,050,353,917.70	1,427,746,982.30	59.0
Гадаад албан томилолт	1,430,201,600.00	873,535,899.60	556,665,700.40	61.1
Дотоод албан томилолт	865,342,100.00	780,451,948.00	84,890,152.00	90.2
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,182,557,200.00	396,366,070.10	786,191,129.90	33.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,134,630,700.00	10,104,343,230.50	3,030,287,469.50	76.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,799,188,400.00	9,272,709,770.50	2,526,478,629.50	78.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,330,900.000	29,583,500.00	50,747,400.00	36.8
Даатгалын үйлчилгээ	12,447,000.00	3,377,908.00	9,069,092.00	27.1
Тээврийн хэрэгслийн татвар	10,630,000.00	8,875,633.00	1,754,367.00	83.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,889,800.00	221,784.00	4,668,016.00	4.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,068,965,300.00	736,356,019.00	332,609,281.10	68.9
Газрын төлбөр	143,121,600.00	50,925,616.00	92,195,984.00	35.6
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,057,700.00	2,293,000.00	12,764,700.00	15.2

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	867,317,800.00	784,807,722.40	82,510,077.60	90.5
Бараа үйлчилгээний бусад зардал	200,284,100.00	163,196,698.20	37,087,401.80	81.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	667,033,700.00	621,611,024.20	45,422,675.80	93.2
ТАТААС	4,748,397,800.00	2,227,981,700.00	2,520,416,100.00	46.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,748,397,800.00	2,227,981,700.00	2,520,416,100.00	46.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,748,397,800.00	2,227,981,700.00	2,520,416,100.00	46.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,042,663,700.00	1,376,437,191.50	666,226,508.50	67.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	22,427,700.00	10,346,395.00	12,081,305.00	46.1
Засгийн газрын гадаад шилжүүлэг	22,427,700.00	10,346,395.00	12,081,305.00	46.1
Бусад урсгал шилжүүлэг	2,020,236,000.00	1,366,090,796.50	654,145,203.50	67.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	219,976,200.00	185,557,600.00	34,418,600.00	84.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,724,505,400.00	1,141,924,796.50	582,580,603.50	66.2
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	75,754,400.00	38,608,400.00	37,146,000.00	51.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	146,515,100,000.00	36,410,244,697.00	110,104,855,303.00	24.9
Барилга байгууламж	136,252,800,000.00	29,281,416,442.00	106,971,383,558.00	21.5
Их засвар	2,335,300,000.00	2,177,926,255.00	157,373,745.00	93.3
Тоног төхөөрөмж	7,927,000,000.00	4,950,902,000.00	2,976,098,000.00	62.5
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	361,128,464.00	(361,128,464.00)	
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(361,128,464.00)	361,128,464.00	
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(361,128,464.00)	361,128,464.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,896	4,089	(193)	105.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	31	27	4	87.1
Төсвийн байгууллага	31	27	4	87.1
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,910	2,017	(107)	105.6
Удирдах ажилтан	85	73	12	85.9
Гүйцэтгэх ажилтан	1,585	1,687	(102)	106.4
Үйлчлэх ажилтан	240	257	(17)	107.1
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,910	2,010	(100)	105.2
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	172	170	2	98.8
Ажлын албаны албан хаагч (АА)	122	112	10	91.8
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	1,323	1,418	(95)	107.2
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	230	262	(32)	113.9
Улс төрийн албан хаагч (УТ)	2	13	(11)	650.0
Шатлалгүй цалин	32	32	-	100.0
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	29	3	26	10.3
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	45	35	10	77.8
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	45	35	10	77.8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	17,708,631.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	17,708,631.70
122	Тусламжийн орлого	-	17,708,631.70
1221	Хандив тусламж /дотоод/	-	17,708,631.70
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	17,708,631.70
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	2,377,719.90
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	960,712.50
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,063,708.60
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	10,306,490.80
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	13,911,092.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	13,911,092.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	13,883,935.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	3,067,724.20
210101	Үндсэн цалин	-	1,092,759.00
210102	Нэмэгдэл	-	93,885.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,865.70
210104	Урамшуулал	-	1,475.60
210105	Гэрээт ажлын хөлс	-	1,867,738.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	382,152.70
210201	Тэтгэврийн даатгал	-	350,828.30
210202	Тэтгэмжийн даатгал	-	7,981.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,656.10
210204	Ажилгүйдлийн даатгал	-	3,695.80
210205	Эрүүл мэндийн даатгал	-	13,990.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	27,962.40
210301	Гэрэл, цахилгаан	-	24,526.50
210303	Цэвэр, бохир ус	-	3,435.90
2104	Хангамж, бараа материалын зардал	-	956,049.10
210401	Бичиг хэрэг	-	95,335.30
210402	Тээвэр, шатахуун	-	475,003.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,277.00
210404	Ном, хэвлэл	-	217,454.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	166,978.50
2105	Нормативт зардал	-	1,022,449.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	889,916.20
210502	Хоол, хүнс	-	118,274.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	14,258.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,347,297.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	908,980.90
210602	Тавилга	-	43,005.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	67,460.00
210604	Урсгал засвар	-	327,850.70
2107	Томиллолт, зочны зардал	-	2,377,862.00
210701	Гадаад албан томиллолт	-	355,991.40
210702	Дотоод албан томиллолт	-	1,988,089.80
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	33,780.80

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,952,007.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,938,768.30
210803	Даатгалын үйлчилгээ	-	892.90
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	2,168.60
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	9,953.90
210807	Газрын төлбөр	-	224.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	0.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,750,431.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,408,756.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	341,675.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	27,157.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	27,157.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	18,542.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	8,615.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	3,797,538.80
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(3,797,538.80)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(3,797,538.80)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Эдийн засаг, хөгжлийн яам нь эрхэм зорилгоо “Шинжлэх ухааны нотолгоонд суурилан эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, инновац, технологи, хувийн хэвшилд суурилсан төрөлжсөн эдийн засгийн бүтцийг хөгжүүлэх, хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн чадавхыг сайжруулж, хүртээмжтэй болгох, бизнесийн эрх чөлөөг тогтвортой хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийг хийх, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах, нэгдсэн бодлогыг тодорхойлох;
- Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах;
- Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, эдийн засгийн коридорын төслүүдийг идэвхжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, санхүү, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүй болон гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах;
- Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.36-д *"төсвийн ерөнхийлөн захирагч" гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг*" гэж заасны дагуу Монгол Улсын ерөнхий сайдын 2026 оны 60 дугаар захирамжаар томилогдсон Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр нь төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагч 28, Засгийн газрын тусгай сан 1, Төрийн өмчит үйлдвэрийн газар 2, Төсвийн төвлөрүүлэн захирагч 2, нийт 34 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэжээ.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин

Төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагаандаа Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын баталсан холбогдох журам заавар.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн "Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай" А/237 дугаар тушаалаар Эдийн засаг, хөгжлийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-д заасны дагуу тус яамны Хяналт, шинжилгээ үнэлгээний газар нь Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, яамны 2025 оны үйл ажиллагааны үр дүнг дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд:

- "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т ЭЗХЯ хариуцан хэрэгжүүлэх зорилтын хэрэгжилт 77.5 хувь;
- "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-нд ЭЗХЯ хариуцан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт 89.4 хувь;

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 94.8 хувь;
- Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 97.5 хувьтай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/113 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэж ирүүлсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэргүй шилжин ирсэн 5 ТШЗ-г харьялах Төсвийн ерөнхийлөн захирагчид /Боловсрол, Шинжлэх, Ухааны сайд/-д шилжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 588,105.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	461,606.3	1,196,227.0	734,620.7
Авлага	351,478.0	340,958.9	(10,519.1)
Урьдчилгаа	11,360.7	10,151.1	(1,209.6)
Бараа материал	6,000.1	5,482.3	(517.8)
Бусад эргэлтийн хөрөнгө	1,324,492.8	1,236,675.1	(87,817.7)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,325,758.8	1,216,168.5	(109,590.3)
Үндсэн хөрөнгө	211,836.4	274,976.0	63,139.6
Нийт хөрөнгийн дүн	3,692,533.1	4,280,638.9	588,105.8
Нийт өр төлбөр	1,895,809.5	2,793,140.5	897,331.0
Засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/	1,796,723.6	1,487,498.4	(309,225.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,692,533.1	4,280,638.9	588,105.8

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бусад эргэлтийн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данстууд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,196,227.0 сая төгрөг болж, өмнөх оноос 734,620.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	1.8	0.7	(1.1)
Төгрөг	0.8	0.7	(0.1)
Касс арилжааны банк	1.0	-	(1.0)
Банкинд байгаа бэлэн мөнгө	198,452.0	72,704.2	(125,747.8)
Төгрөг	171,673.4	26,155.8	(145,517.5)
Төрийн сангийн харилцах	96,823.8	12,039.2	(84,784.6)
Монгол банкин дахь харилцах	71,412.1	10,060.5	(61,351.6)
Арилжааны банк дахь харилцах	3,437.4	4,056.1	618.7
Гадаад валют	26,778.6	46,548.4	19,769.8
Монгол банк дахь харилцах	17,839.6	10,810.0	(7,029.5)
Арилжааны банк дахь харилцах	4,887.9	35,738.4	30,850.5
Бусад төсөл, нөөцийн харилцах	4,051.2	-	(4,051.2)
Хадгаламж	263,152.5	1,123,522.1	860,369.6
Дүн	461,606.3	1,196,227.0	734,620.8

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгийн 734,620.8 сая төгрөгөөр өссөн нь Монгол улсын хөгжлийн банк ХХК 500.0 сая ам.долларын татан төвлөрүүлсэн хөрөнгийг хадгаламжид байршуулсантай холбоотой байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 99.0 хувь буюу 1,183,715.7 сая төгрөг нь Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бөгөөд үүнээс 1,123,522.1 сая төгрөг хадгаламжийн дансны үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 0.9 хувь буюу 11,915.9 сая төгрөг нь ЭЗХС-ын хөрөнгө оруулалтын дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бөгөөд үүнээс 7,637.8 сая төгрөг буюу 64.1 хувь нь барьцаа данс, 4,278.1 сая төгрөг буюу 35.9 хувь нь техник хяналтын дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт

- Дотоод журам зөрчиж мөнгөн тусламж илүү олгосон, тайланг бүрэн бэлтгээгүй, ТАЗ-ын зөвшөөрөлгүй бүтэц, орон тоо өөрчилж томилгоо хийсэн. /ЗГХХГ 383.6 сая төгрөг/;
- Ажилтан, ТУЗ-ийн гишүүдэд хувийн даатгалын зардлыг санхүүжүүлсэн, ТУЗ-ийн гишүүнд сургалтын зардал олгосон. /Монгол улсын хөгжлийн банк ХХК 92.3 сая төгрөг/;
- Ноогдол ашиг, санхүүжилтийн үлдэгдлийг хуульд нийцүүлээгүй./Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ 58.0 сая төгрөг/
- Яаманд бүртгэлгүй автомашины шатахууны зардлыг санхүүжүүлсэн, бодит хэрэгцээнээс илүү лиценз худалдан авсан. /ЭЗХЯ 23.6 сая төгрөг/
- Даатгалын системд бүртгэл буруу хийснээс санхүүжилт авах боломж алдсан, төлбөрийн цахим баримтыг дутуу бүртгэж орлогыг бүрэн тайлагнаагүй./ Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 31.6 сая төгрөг/
- Тусгай зөвшөөрөлгүй байгууллагаас эм, урвалж худалдан авсан. /Биологийн хүрээлэн 0.9 сая төгрөг/
- Анхан шатны баримтын бүрдлийг холбогдох хууль журамд нийцүүлэн бүрэн бүрдүүлээгүй. /ЭЗХЯ 280.5 сая төгрөг, Ди Би Эм ассет менежмент ХХК 41.8 сая төгрөг, хими химийн технологийн хүрээлэн/
- Төрийн сан, банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй. /Монгол улсын хөгжлийн банк ХХК 11,091.9 сая төгрөг, ЗГХХГ/

- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг төлөвлөөгүйгээр зарцуулсан. /Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн 123.0 сая төгрөг/
- Сангийн сайдын баталсан журамд заасан гадаад томилолтын тарифаас илүү тооцож олгосон. /ЭЗХЯ 248.2 сая төгрөг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ 12.9 сая төгрөг, Ди Би Эм лизинг ХХК 6.9 сая төгрөг, Монгол улсын хөгжлийн банк ХХК 4.5 сая төгрөг, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 0.5 сая төгрөг/
- Төсвийн төсөлд тусгаж батлуулаагүй, байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй үр ашиггүй зардлуудыг санхүүжүүлсэн. /ЗГХХГ 305.0 сая төгрөг, ЭЗХЯ 68.4 сая төгрөг, Ди Би Эм ассет менежмент ХХК 53.6 сая төгрөг, ҮШУТС 19.9 сая төгрөг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ 4.2 сая төгрөг/
- Гэрээт ажилтныг шууд хөдөлмөрийн гэрээгээр авч, цалингийн сангаас цалинжуулсан. /ЗГХХГ 419.2 сая төгрөг/
- Үр дүнгийн урамшуулал, нэмэгдэл цалин, илүү олгосон, бүх нийтийн амралтын өдөр ажилласан ажиллагсдын цагийн бүртгэлийг баталгаажуулаагүй. /ЗГХХГ 119.1 сая төгрөг, ШУА 51.5 сая төгрөг, Монгол улсын хөгжлийн банк ХХК 35.6 сая төгрөг, Олон улс судлалын хүрээлэн 19.1 сая төгрөг, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 4.9 сая төгрөг, Ди Би Эм ассет менежмент ХХК 4.3 сая төгрөг, Биологийн хүрээлэн 2.0 сая төгрөг, Ди Би Эм лизинг ХХК 1.7 сая төгрөг, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 0.8 сая төгрөг/
- Цалин, хөлс олгоходоо хууль, журамд нийцүүлээгүй илүү олгосон. /Монгол улсын хөгжлийн банк ХХК 211.1 сая төгрөг, ЗГХХГ 169.8 сая төгрөг, Ди Би Эм лизинг ХХК 3.7 сая төгрөг, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 0.4 сая төгрөг/
- Ажилтны НДШ, ХХОАТ бодоходоо буруу тооцоолж, дутуу суутгасан, суутгаагүй. /Хими химийн технологийн хүрээлэн 5.7 сая төгрөг, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн 1.8 сая төгрөг, Газарзүй геоэкологийн хүрээлэн 1.3 сая төгрөг, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн 0.1 сая төгрөг/
- Хоол унааны хөнгөлөлтийг илүү олгосон. /Монгол улсын хөгжлийн банк ХХК 3.7 сая төгрөг, Ди Би Эм лизинг ХХК 0.2 сая төгрөг/
- Албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй /Биологийн хүрээлэн, Газарзүй геоэкологийн хүрээлэн, Хими химийн технологийн хүрээлэн/
- Эдийн засгийн ангилал зөрүүлж зарцуулалт гаргасан /ЗГХХГ 66.6 сая төгрөг, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 22.4 сая төгрөг/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 340,958.9 сая төгрөг болж, өмнөх оноос 10,519.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	16.5	24.7	8.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	419.5	205.3	(214.2)
Татаас, санхүүжилтийн авлага	3,364.4	3,416.2	51.8
Зээлийн хүүгийн авлага	243,124.5	242,412.5	(712.0)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	17.5	2,600.4	2,582.9
Бусад авлага	104,535.6	92,299.8	(12,235.8)
Байгууллагаас авах авлага	104,291.1	92,085.2	(12,205.9)
Хувь хүмүүсээс авах авлага	244.5	214.6	(29.9)
Дүн	351,478.0	340,958.9	(10,519.1)

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлага дансны үлдэгдлийн 98.6 хувь буюу 336,117.5 сая төгрөг нь Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн авлагын үлдэгдэл бөгөөд үүнээс 242,412.5 сая төгрөг нь зээлийн хүүгийн авлага байна.

Авлага дансны үлдэгдэл 10,519.1 сая төгрөгөөр буурсан нь Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн Татвар, НДШ-ийн авлага 2,582.9 сая төгрөгөөр нэмэгдэж, хувь хүмүүсээс авах авлага 12,734.0 сая төгрөгөөр буурсанаас голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. /Монгол улсын хөгжлийн банк ХХК 338,084.7 сая төгрөг, Ди Би Эм лизинг ХХК 16,878.5 сая төгрөг, Ди Би Эм ассет менежмент ХХК 109.0 сая төгрөг, Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн 33.9 сая төгрөг/

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 10,151.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1,209.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	11,075.1	10,036.2	(1,038.9)
Урьдчилгаа тооцоо	285.6	114.8	(170.8)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	80.2	17.6	(62.6)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	2.0	2.0
Томилолтын урьдчилгаа	205.4	95.2	(110.2)
ДҮН	11,360.7	10,151.0	(1,209.7)

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны үлдэгдлийн 88.9 хувь буюу 8,984.9 сая төгрөг нь Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас төслүүдэд олгосон санхүүжилтийн урьдчилгаа бол 7 хувь буюу 704.8 сая төгрөг нь Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн урьдчилж гарсан зардал байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,209.7 сая төгрөгөөр буурсан нь Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн өмнөх онуудад олгосон эрдэм шинжилгээний төсөл, сэдэвт ажлын гүйцэтгэлийг хаасан 4,334.1 сая төгрөг, тайлант онд шинээр олгосон 2,980.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 5,482.3 сая төгрөг болж, өмнөх оноос 517.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	754.4	604.0	(150.4)
Тусгай зориулалттай материал	661.4	543.6	(117.8)
Эм боох материал	93.0	60.4	(32.6)
Дуусаагүй үйлдвэрлэл	9.7	0.1	(9.6)
Бэлэн бүтээгдэхүүн	1,500.2	1,443.4	(56.8)
Хангамжийн материал	3,531.7	3,244.4	(287.3)
Бичиг хэргийн материал	350.4	172.4	(178.0)
Аж ахуйн материал	1,296.1	1,429.0	132.9
Сэлбэг хэрэгсэл	120.5	70.0	(50.5)
Түлш, шатах тослох материал	35.8	12.9	(22.9)
Барилгын засварын материал	66.3	20.0	(46.3)
Хүнсний материал	5.2	3.6	(1.6)
Бусад хангамжийн материал	1,657.4	1,536.5	(120.9)
Мал амьтад	204.1	190.4	(13.7)
ДҮН	6,000.1	5,482.3	(517.8)

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Тайлант онд байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 19,545.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 12.0 сая төгрөгийн бараа материал хандиваар хүлээн авч, 669.0 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 115.4 сая төгрөгийн бараа материалыг бусад ангиллаар бүртгэлд тусгаж, 19,382.8 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 871.2 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн өгч, 605.4 сая төгрөгийн бараа материалыг бусад ангиллаар бүртгэлээс хасч, 5,482.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдлийн 0.7 хувь буюу 41.2 сая төгрөг нь төрийн өмчит үйлдвэрийн газрын үлдэгдэл, 99.3 хувь буюу 5,441.1 сая төгрөгийн нь төсвийн байгууллагын үлдэгдэл, байна. Үүнээс бараа материалын дансны үлдэгдлийн 20.4 хувь буюу 1,117.5 сая төгрөгийг Ургамал, газар тариалангийн хүрээлэн, 15.9 хувь буюу 869.0 сая төгрөгийг Биологийн хүрээлэн, 11.5 хувь буюу 629.1 сая төгрөгийг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн, 6.9 хувь буюу 377.5 сая төгрөгийг Археологийн хүрээлэн, 5.5 хувь буюу 303.4 сая төгрөгийг Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн, 5.4 хувь буюу 294.5 сая төгрөгийн ШУА-ийн тэргүүлэгчдийн газар тус тус голлон эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- Бараа материалыг жилийн эцсийн тооллогоор баталгаажуулаагүй, аудитын түүвэр тооллогоор бараа материал дутагдсан, шууд зардлаар бүртгэсэн. /Биологийн хүрээлэн 40.3 сая төгрөг, Монгол улсын хөгжлийн банк ХХК 24.1 сая төгрөг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ 16.8 сая төгрөг, Ди Би Эм лизинг ХХК 12.5 сая төгрөг, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 4.2 сая төгрөг, Ди Би Эм ассет менежмент ХХК 4.1 сая төгрөг/
- Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэрэгүйгээр бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн. /ЭЗХЯ 13.5 сая төгрөг/

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 1,236,675.1 сая төгрөг болж, өмнөх оноос 87,817.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	73,115.9	7,143.7	(65,972.2)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	1,174,868.3	1,226,289.8	51,421.5
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	76,508.6	3,241.6	(73,267.0)
ДҮН	1,324,492.8	1,236,675.1	(87,817.7)

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийн 98.7 хувь буюу 1,220,713.8 сая төгрөг нь ЭЗХС-ын хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл, 0.8 хувь буюу 10,385.3 сая төгрөг нь Монгол улсын хөгжлийн банк ХХК, 0.5 хувь буюу 5,576.0 сая төгрөг нь ЭЗХЯ-ын бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн их засварын ажил тус тус эзэлж байна.

ЭЗХС-ын хөрөнгө оруулалтын дансны бусад эргэлтийн хөрөнгө дансанд 31,858.9 сая төгрөгийн 76 ТЭЗҮ, 1,181,366.7 сая төгрөгийн барилга байгууламж, 6,176.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1,311.5 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл 87,817.7 сая төгрөгөөр буурсан нь Монгол улсын хөгжлийн банк ХХК Шинэ яармагийн борлуулах зориулалттай хөрөнгөнд бүртгэлтэй 74,041.6 сая төгрөгийн орон сууцуудыг 2025 онд ангиллын залруулга хийж, өмчлөх бусад хөрөнгөнд бүртгэсэнээс голлон шалтгаалсан байна.

3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эцсийн үлдэгдэл 1,216,168.5 сая төгрөг болж, өмнөх оноос 109,590.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Урт хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	246,835.0	266,530.1	19,695.1
Төгрөг	246,835.0	227,402.6	(19,432.4)
Гадаад валют	-	39,127.5	39,127.5
Урт хугацаат зээл	1,078,923.7	949,638.4	(129,285.3)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	49,436.7	44,179.5	(5,257.2)
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	683,124.6	692,823.1	9,698.5
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	346,362.4	212,635.8	(133,726.6)
Дүн	1,325,758.7	1,216,168.5	(109,590.2)

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл нь Монгол улсын хөгжлийн банк ХХКны урт хугацаат хөрөнгө оруулалт бөгөөд нийт үлдэгдлийн 78.1 хувь нь байгууллагуудад олгосон урт хугацаат зээл байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оноос 109,590.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын санг 122,499.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнээс голлон шалтгаалсан байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 274,976.0 сая төгрөг болж, өмнөх оноос 63,139.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	89,576.1	99,580.6	10,004.5
Барилга, байгууламж, орон сууц	63,986.3	62,571.0	(1,415.3)
Авто-тээврийн хэрэгсэл	1,724.1	2,662.0	937.9
Машин тоног төхөөрөмж(компьютер)	17,560.4	27,889.7	10,329.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,069.1	3,211.6	142.5
Түүх соёл, музейндурсгалт зүйлс	2,122.5	2,122.5	-
Бусад үндсэн хөрөнгө	747.0	749.5	2.5
Дуусаагүй барилга, байгууламж	3.6	3.6	-
Ном	363.1	370.7	7.6
Биет бус хөрөнгө	32,425.2	32,314.3	(110.9)
Програм хангамж	489.4	915.0	425.6
Бусад биет бус хөрөнгө	31,935.8	31,399.3	(536.5)
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	89,835.1	143,081.1	53,246.0
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	89,835.1	143,081.1	53,246.0
Дүн	211,836.4	274,976.0	63,139.6

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 166,292.7 сая төгрөг буюу 60.5 хувь нь Монгол улсын хөгжлийн банк, 108,683.3 сая төгрөг буюу 39.5 хувь нь төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 63,139.6 сая төгрөгөөр өсөхөд тайлант хугацаанд 5,690.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 611.6 сая төгрөгийн хөрөнгө хандиваар, 385.3 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 81,693.5 сая төгрөгийн хөрөнгийг бусад байдлаар буюу

Монгол улсын хөгжлийн банк ХХК Шинэ яармагийн борлуулах зориулалттай хөрөнгөнд бүртгэлтэй 74,041.6 сая төгрөгийн орон сууцуудыг 2025 онд ангиллын залруулга хийж, өмчлөх бусад хөрөнгөнд бүртгэсэн, 5,978.9 сая төгрөгийн дахин үнэлгээний нөөц нэмэгдсэн зэргээс голлон нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд 22,600.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 378.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 5.1 сая төгрөгийг хөрөнгийг бусад шалтгаанаар бүртгэлд тусгаж, 9,848.7 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдолоор буурсан байна.

Аудитын илрүүлэлт

- Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, жилийн эцсийн тооллогоор үндсэн хөрөнгө дутагдсан, тооллогод хамруулаагүй. /Монгол улсын хөгжлийн банк ХХК 144,923.5 сая төгрөг, ЗГХХГ 10.4 сая төгрөг, Ди Би Эм лизинг ХХК 2.4 сая төгрөг, Ди Би Эм ассет менежмент ХХК 2.0 сая төгрөг, Үндэсний шинжлэх ухаан технологийн сан, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн/
- Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн төвилга, эд хогшил, бусад эргэлтийн хөрөнгө бүртгэлтэй. /ЗГХХГ 460.8 сая төгрөг, Ди Би Эм ассет менежмент ХХК 128.7 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийг гадаад нэршлээр бүртгэсэн. /Физик технологийн хүрээлэн 216.7 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийг зах зээлийн үнээс өндөрөөр худалдан авсан. /ЭЗХЯ 2.6 сая төгрөг/
- Нэмэлт төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэхдээ ТӨБЗГ-аас зөвшөөрөл аваагүй. /Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн 5.7 сая төгрөг/;
- НБББББ-ийг мөрдөж ажиллаагүйгээс худалдан авсан хөрөнгийг буруу ангилан бүртгэсэн. /Одон орон геофизикийн хүрээлэн 2 сая төгрөг, ЗГХХГ/

3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2,793,140.5 сая төгрөг болж, өмнөх оноос 897,331.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	168,791.4	222,798.7	54,007.3
Богино хугацаат зээлийн өглөг	107,972.6	58,660.0	(49,312.6)
Гадаад валют	107,972.6	58,660.0	(49,312.6)
Бусад гадаад эх үүсвэрээс	107,972.6	58,660.0	(49,312.6)
Өглөг	60,738.5	164,138.7	103,400.2
Ажилчидтай холбогдсон өглөг	275.4	367.0	91.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	129.9	191.8	61.9
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	36.5	76.6	40.1
Зээлийн хүүгийн өглөг	46,192.1	88,728.3	42,536.2
Бусад өглөг	14,104.6	74,775.0	60,670.4
Байгууллагад төлөх өглөг	11,988.1	35,391.2	23,403.1
Хувь хүмүүст төлөх өглөг	108.5	38.6	(69.9)
Татварын өглөг /ТӨҮГ/	2,002.5	39,004.9	37,002.4
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	4.8	104.7	99.9
Дансны өглөг /ТӨҮГ/	0.7	235.6	234.9
Урьдчилж орсон орлого	80.3	-	(80.3)
Бусад урьдчилж орсон орлого	80.3	-	(80.3)
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,727,018.1	2,570,341.8	843,323.7
Урт хугацаат үнэт цаас	1,354,247.8	2,362,728.4	1,008,480.6
Төгрөг	563,748.5	487,825.7	(75,922.8)
Бонд	563,748.5	487,825.7	(75,922.8)
Гадаад валют	790,499.3	1,874,902.7	1,084,403.4
Бонд	790,499.3	1,874,902.7	1,084,403.4
Урт хугацаат зээл	372,770.3	207,613.4	(165,156.9)
Төгрөг	44,288.0	44,288.0	-
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	44,218.0	44,218.0	-
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	70.0	70.0	-

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гадаад валют	328,482.3	163,325.4	(165,156.9)
Гадаадын арилжааны банк	293,247.4	163,311.5	(129,935.9)
Хойшлогдсон өр төлбөр /ТӨҮГ/	35,234.9	13.9	(35,221.0)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,895,809.5	2,793,140.5	897,331.0

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөрийн үлдэгдлийн 2,789,433.9 сая төгрөг буюу 99.9 хувь нь Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн өр төлбөр бөгөөд үүнээс 2,570,158.5 сая төгрөг буюу 92.3 хувь нь урт хугацаат өр төлбөр байна. Мөн 3.706.7 сая төгрөг буюу 0.1 хувь нь төсөвт байгууллагын өр төлбөр байна.

Өр төлбөрийн үлдэгдэл 897,331.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Монгол улсын хөгжлийн банк ХХК олон улсын зах зээлд жилийн 8.5 хувийн хүүтэй 500 сая ам.долларын барьцаагүй өрийн бичиг гаргасанаас голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

- Төсвийг зохистой удирдаагүйгээс өглөг үүсгэсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй, бүртгэлд тусгаагүй, илүү, дутуу тайлагнасан. /ЗГХХГ 488.3 сая төгрөг, ЭЗХЯ 89.4 сая төгрөг, Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн/.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,487,498.4 сая төгрөг болж, өмнөх оноос 309,225.2 сая төгрөгөөр буурсан байна байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	55,273.5	54,690.0	(583.5)
Улсын төсвийн оруулсан хөрөнгө	55,273.5	54,690.0	(583.5)
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,216,300.3	1,216,885.5	585.2
Хуримтлагдсан үр дүн	480,201.2	163,201.9	(316,999.3)
Өмнөх үеийн үр дүн	494,105.3	429,627.0	(64,478.2)
Тайлант үеийн үр дүн	(13,904.1)	(266,425.1)	(252,521.0)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	44,948.5	52,720.9	7,772.3
Дүн	1,796,723.5	1,487,498.4	(309,225.2)

Эх сурвалж: МУ-ын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо дансны 82.7 хувь буюу 1,230,849.5 сая төгрөг нь Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн үлдэгдэл, 17.3 хувь буюу 256,648.9 сая төгрөг нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна. Тайлант үеийн үр дүн 309,225.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,918,046.5 сая төгрөгөөр тооцон, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/1396 тоот албан бичгээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 18,434.6 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 1,953.3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,210.8 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 4,223.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 11,942.7 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 17,428.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 385,619.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,380.4 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 6,517.3 сая төгрөг, хөрөнгийн зардлыг 4,195,412.8 сая төгрөгөөр бууруулж, нормативт зардлыг 335.2 сая төгрөг, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас зардлыг 4,748.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 27 арга хэмжээг санхүүжүүлэхээр 275,007.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 15,520.0 сая төгрөгөөр бууруулж 259,487.2 сая төгрөг болгон тодотгожээ. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 4,101.5 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 551.9 сая төгрөг, нормативт зардлыг 52.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 12,033.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 194.6 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 161.2 сая төгрөгөөр бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8.6 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 198.6 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 333.3 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 1,034.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар харьяа төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжүүлэх 2,388.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө баталж, гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанаас 2,334.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, биелэлт 97.8 хувьтай гарсан нь Оюуны өмчийн газрын өргөдөл, гомдлыг хүлээн авч, хяналт тавьж шийдвэрлэх зорилтот түвшинд хүрээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 11. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт

/сая төгрөгөөр/

Д/д	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,388.3	2,334.7	53.4	97.8

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагч нь Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 2025 оны 01/3123 тоот албан бичгээр төсвийн зохицуулалт хийх хүсэлтийг хүргүүлж, төсвийн хуваарьт 1 удаагийн 902.6 сая төгрөгийн өөрчлөлт хийлгэсэн байна.

Төсөвт зохицуулалт хийсэн шалтгааныг авч үзвэл Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасан төсөвт зохицуулалт хийх нөхцөлөөс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсны дагуу сайдын багц дахь зарим байгууллагуудын ажил, үйлчилгээ явуулсан өр төлбөрийг барагдуулах, ажиллах хэвийн нөхцөлөөр хангах шаардлага гарсантай холбоотойгоор төсвийн хуваарьт дараах өөрчлөлтийг хийлгэжээ. Үүнд:

- **Эдийн засаг, хөгжлийн яам** бараа үйлчилгээний бусад зардлыг 170.0 сая төгрөг, нормативт зардлыг 2.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 321.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4.3 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 592.0 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 157.1 сая төгрөгөөр тус тус бууруулсан;

- **Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар** бараа үйлчилгээний бусад зардлыг 245.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- **Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ** бараа үйлчилгээний бусад зардлыг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- **Оюуны өмчийн газар** байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 50.0 сая төгрөг, бараа материалын зардлыг 3.0 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс 5.0 сая төгрөг, нормативт зардлыг 2.0 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 70.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 125.0 сая төгрөгөөр бууруулсан;
- **Шинжлэх ухааны паркийн захиргаа** бараа үйлчилгээний бусад зардлыг 5.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- **Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан** байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 139.7 сая төгрөг, нормативт зардлыг 0.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- **Ургамал, газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн** цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 151.2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4.3 сая төгрөг, байр ашиглалтын зардлыг 3.7 сая төгрөг, бараа материалын зардлыг 5.0 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс 1.1 сая төгрөг, нормативт зардлыг 2.6 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.4 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 10.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх төлбөр хураамжийн зардлыг 2.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.0 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 1.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- **Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн** бараа материалын зардлыг 2.1 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс 2.0 сая төгрөг, нормативт зардлыг 0.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 15.0 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 10.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 10.2 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 25.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- **Анагаах ухааны эрдэм шинжилгээний хүрээлэн** ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 13.0 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 14.0 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 23.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, урсгал шилжүүлгийн зардлыг 21.5 сая төгрөгөөр бууруулсан;
- **Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн** цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 21.0 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 23.7 сая төгрөг, байр ашиглалтын зардлыг 13.3 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 41.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн;
- **Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн** бараа материалын зардлыг 5.2 сая төгрөг, нормативт зардлыг 10.0 сая төгрөг, томилолт, зочны зардлыг 5.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 134,470.6 сая төгрөг буюу 51.8 хувьтай байгаа нь Эдийн засаг хөгжлийн төлөвлөлт /70201/ хөтөлбөрийн Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж /80912/ арга хэмжээнээс 110,104.9 сая төгрөг, Гүйцэтгэх засаглалын удирдлага /71803/ хөтөлбөрийн Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/ арга хэмжээнээс 2,450.1 сая төгрөг, Шинжлэх ухаан технологи /71805/ хөтөлбөрийн Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/ арга хэмжээнээс 4,121.1 сая төгрөг, Эрдэм шинжилгээ, судалгааны ажил /80215/ арга хэмжээнээс 1,361.3 сая төгрөг, Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт /70428/ Ажил олгогчоос олгох

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тэтгэмж, урамшуулал /80802/ арга хэмжээнээс 212.7 сая төгрөг тус тус дутуу зарцуулснаас голлон шалтгаалжээ.

Хүснэгт 12.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд		259,487.2	134,470.6	124,392.7	51.8
70201	Эдийн засаг хөгжлийн төлөвлөлт	165,909.8	50,582.2	115,327.6	30.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	13,127.2	10,929.2	2,198.0	83.3
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	107.6	45.0	62.6	41.8
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	214.3	104.5	109.9	48.8
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	547.2	519.9	27.2	95.0
80239	Тээврийн үйлчилгээ	50.0	33.0	17.0	66.0
80404	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,748.4	2,228.0	2,520.4	46.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	72.7	67.0	5.7	92.2
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	527.4	245.4	282.0	46.5
80912	Барилга байгууламж	136,252.8	29,281.4	106,971.4	21.5
	Их засвар	2,335.3	2,177.9	157.4	93.3
	Тоног төхөөрөмж	7,927.0	4,950.9	2,976.1	62.5
71803	Гүйцэтгэх засаглалын удирдлага	14,778.7	12,229.5	2,549.20	82.8
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	13,722.1	11,272.0	2,450.1	82.1
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	250.0	249.8	0.2	99.9
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	213.5	178.1	35.4	83.4
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	284.3	235.7	48.7	82.9
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	308.7	294.0	14.7	95.2
71805	Шинжлэх ухаан технологи	75,422.3	69,119.1	6,303.2	91.6
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	65,871.8	61,750.7	4,121.1	93.7
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	5,320.3	3,959.0	1,361.3	74.4
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	537.5	332.2	205.3	61.8
80219	Харуул, хамгаалалтын зардал	484.5	357.0	127.6	73.7
80220	Холбооны суваг ашигласны хөлс	64.5	57.8	6.7	89.6
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	169.9	169.2	0.7	99.6
80404	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	5.9	5.9	-	100.0
80509	Олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	22.4	10.3	12.1	46.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,445.1	1,058.1	387.0	73.2
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1,431.9	1,350.4	81.4	94.3
81805	Телевизийн хөтөлбөрөөр боловсрол олгох	68.4	68.4	-	100.0
70428	Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт	2,752.5	2,539.8	212.7	92.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,534.4	2,534.4	-	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	218.1	5.4	212.7	2.5

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу 2025 оны төсвийн тодотголоор харьяа байгууллагуудын орон тоо, цалингийн санг бууруулан тодотгосон байна. Орон тоог бууруулсан байгууллагуудыг жагсаавал:

- ЭЗХЯ батлагдсан орон тоог 151 болгон удирдах 10, гүйцэтгэх 5 орон тоо;
- Монгол улсын хөгжлийн банк ХХК батлагдсан орон тоог 99 болгон удирдах 13, гүйцэтгэх 33 орон тоо;
- Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ орон тоог 25 болгон удирдах 6 орон гүйцэтгэх 19 орон тоо;
- Оюуны өмчийн газар орон тоог 54 болгон удирдах 2 орон гүйцэтгэх 3 орон тоогоор тус тус бууруулсан байна.

Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн жагсаалт, тэдгээрийн харьяалал, орон тооны дээд хязгаарыг баталсан байдаг. Энэ тогтоолд өөрчлөлт ороогүйтэй холбоотой албан хаагчдыг цомхотгох үндэслэлгүй гэсэн шалтгаанаар зарим хүрээлэн орон тоог бууруулалгүй ажилласан бол Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар орон тооны цомхотгол хийгээгүй боловч тус газар нь 2025 онд батлагдсан 150 орон тооноос 120-138 орон тооны гүйцэтгэлтэй ажилласан байна.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяа байгууллагуудын хоол, унааны зардлыг хөдөлмөрийн дотоод журам, үйлдвэрчний эвлэлийн хамтын гэрээнд тусгасны дагуу ажлын нэг өдөрт олгох дүнг задлан харуулбал:

- Биологийн хүрээлэн 36.0 мянган төгрөг;
- Археологийн хүрээлэн, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Математик тоон технологийн хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэн, ШУА-Тэргүүлэгчдийн газар, Геологийн хүрээлэн, Газарзүй, геоэкологийн хүрээлэн, Одон орон геофизикийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Технологийн инкубатор, Түүх угсаатны зүйн хүрээлэн, Физик технологийн хүрээлэн, Философийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн 35.0 мянган төгрөг;
- Эдийн засаг, хөгжлийн яам, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн 30.0 мянган төгрөг;
- Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан 27.0 мянган төгрөг;
- Анагаах ухааны хүрээлэн, Монгол улсын хөгжлийн банк ХХК, Ди Би Эм ассет менежмент ХХК 25.0 мянган төгрөг;
- Оюуны өмчийн газар, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн 20.0 мянган төгрөг;
- Хими, химийн технологийн хүрээлэн, Тархи, сэтгэл судлалын хүрээлэн 17.5 мянган төгрөг;
- Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэн 10.0 мянган төгрөг;
- Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн 6.0 мянган төгрөг.

Гадаад томилолтын зардлаас тайланд онд харья төрийн өмчит үйлдвэрийн газрууд 120.9 сая төгрөгийн 9 арга хэмжээ, төсвийн байгууллагууд 309.4 сая төгрөгийн 81 арга хэмжээ төлөвлөснөөс эрх бүхий этгээдийн тушаал шийдвэртэйгээр төрийн өмчит үйлдвэрийн газрууд 120.6 сая төгрөгийн 9 арга хэмжээ, төсвийн байгууллагууд 291.0 сая төгрөгийн 79 арга хэмжээг,

улсын төсвөөс, 151.4 сая төгрөгийн 14 арга хэмжээг нэмэлт санхүүжилтийн данснаас тус тус хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяа байгууллагууд 42.4 сая төгрөгийн 34 санхүү, тайлагналын программ, 79.4 сая төгрөгийн 10 дотоод ажил, бичиг хэрэг хөтлөлтийн программ, 122.2 сая төгрөгийн 8 сервер, сүлжээ, вирусийн хамгалалтын программ, 143.5 сая төгрөгийн мэдээллийн сан үүсгэх, төслийн давхцал шалгах 4 программ, 521.7 сая төгрөгийн 3 газар хөдлөлт бүртгэлийн программ, 4.0 сая төгрөгийн бусад программ, нийт 913.2 сая төгрөгийн 64 программ хангамж, лицензийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаагаас 891.6 сая төгрөгийн 45 программ хангамж данс бүртгэлд бүртгэлтэй байна.

Сургалт семинар, хурал зөвлөгөөний арга хэмжээтэй холбоотой тайланд онд харья төрийн өмчит үйлдвэрийн газрууд 298.0 сая төгрөгийн 24, төсвийн байгууллагууд 568.1 сая төгрөгийн 81 арга хэмжээ төлөвлөснөөс эрх бүхий этгээдийн тушаал шийдвэртэйгээр төрийн өмчит үйлдвэрийн газрууд 269.0 сая төгрөгийн 24 арга хэмжээ, төсвийн байгууллагууд 529.0 сая төгрөгийн 80 арга хэмжээг, улсын төсвөөс, 75.4 сая төгрөгийн 19 арга хэмжээг нэмэлт санхүүжилтийн данснаас тус тус хэрэгжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь нь төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 100 хувийн эзэмшилтэй Монгол улсын хөгжлийн банк ХХК, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ, Төсвийн ерөнхийлөн захирагчийн 100 хувийн эзэмшилтэй Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллад 3 төрийн өмчит үйлдвэрийн газар харьяалагдаж байгаагаас 1 УТҮГ, 2 ТӨААТҮГ байна. Тайлант оны ашиг, алдагдлийн дүнг задлан харуулбал:

- Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг 9,600.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар ТУЗ баталсан боловч гүйцэтгэлээр 138,422.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг ашиг, алдагдалгүйгээр баталснаас, гүйцэтгэлээр 613.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяа байгууллагууд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх зорилгоор тайлант онд 36 аж ахуй нэгжтэй 327.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 327.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/21 дугаартай тушаалын дагуу эрхлэх асуудлын хүрээний харьяа төсөвт болон төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үндсэн үйл ажиллагааны урсгал болон хөтөлбөр, арга хэмжээний зардал, улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталсан.

Тайлант онд 19 байгууллагын 25,396.0 сая төгрөгийн 47 Нээлттэй тендер шалгаруулалтын арга, 4,782.5 сая төгрөгийн 71 харьцуулалтын арга, 1,843.6 сая төгрөгийн 132 шууд худалдан авалтын арга, 244.3 сая төгрөгийн 14 нэг эх үүсвэрээс худалдан авах арга, 366.5 сая төгрөгийн 3 ерөнхий

гэрээний аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэлээр 27,172.7 сая төгрөгийн 231 гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлж зохион байгууллаагүй, ижил төстэй байдлаар нь багцлаагүй, шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтааж шууд худалдан авсан. /ЗГХХГ 94.6 сая төгрөг, ҮШУТС 461.7 сая төгрөг, Археологийн хүрээлэн 87.6 сая төгрөг./

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн нэгтгдүгээр хавсралтаар баталсан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 4 хөтөлбөрийн 8 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ. Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлтийг ЭЗХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас үнэлээгүй байна. Тайлант оны төсвийн гүйцэтгэл 51.8 хувьтай байхад ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилтийн дундаж биелэлт нь 160.6 хувьтай байгаа нь үндэслэлгүй бөгөөд хөтөлбөр, арга хэмжээний зорилтот түвшний үзүүлэлтийн үр дүнг үнэлэх боломжгүй байна.

Хүснэгт 13.Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагч	Хөтөлбөрийн хүрэх үр дүн	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	
ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД					
	70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт				
18.1	18.1.1	Дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын хүрээг тодорхой болсон байна.	Бодлого, төлөвлөлтийн баримт бичиг	2	2
	18.1.2	Макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах төсвийн бодлогын чиглэл, эдийн засгийн хэт халалт, уналтын эсрэг бодлого оновчтой тодорхойлогдсон байна.	Эрх зүйн баримт бичиг	1	1
	70428 Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт				
18.2	18.2.1	Хувийн өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна.	Оюуны өмчийн бүтээлийн сан бүрдүүлэлт /аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн гэрээ, хэлэлцээрийн баталгаажилт/	4200	6399
			Оюуны өмчийн мэдээлэл, сургалт хийх, лавлагаа гаргах	70	370
			Хяналт тавьж шийдвэрлэх оюуны өмч	450	62
	71805 Шинжлэх ухаан, технологи				
18.3	18.3.1	Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэн байна.	Судалгаа боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	1600	1666
			Эрдэм шинжилгээ, судалгааны менежментийг боловсронгуй болгож,	13000	14022

			өрсөлдөх чадварыг дээшлүүлэх		
			Шинжлэх ухаан, технологийн үр дүн, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх	25	27
	71803 Гүйцэтгэх засаглалын удирдлага				
18.4	18.4.1	Хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох арга хэмжээг авсан байна.	Хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ сайжирч, үр дүн, үр нөлөө гарах	100	100
			Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах	5	5
			Мэргэжил, арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах	1	1
			Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах	2	2
	18.4.2	Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулсан байна.	Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үр нөлөө, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх	100	100
			Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах	2	4
			Мэргэжил, арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах	1	4
			Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах	1	2
	18.4.3	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан байна.	Иргэн, хуулийн этгээд болон төрийн албан хаагчийн сэтгэл ханамж дээшилсэн байдал	100	100
			Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах	2	3
			Мэргэжил, арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах	1	4
			Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах	1	2
	18.4.4	Хууль ёсыг сахиулж, сахилга, хариуцлагыг дээшлүүлсэн байна.	Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах	50	65
			Мэргэжил, арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах	1	1
			Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах	1	1

Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт хөтөлбөрийн "Хяналт тавьж шийдвэрлэх оюуны өмч" зорилтот түвшиндээ хүрээгүй нь 2025 онд иргэн, хуулийн этгээдээс 450 гомдол хүлээн авч, хяналт тавьж, шийдвэрлэхээр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 62 гомдол ирсэн байна.

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 2,377.7 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 960.7 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4,063.7 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10,306.5 сая төгрөг, нийт 17,708.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд нь нэмэлт төсвийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2, 47.1.3, 47.1.5-т заасан эх үүсвэрээс хуулийн дагуу бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр, бараа, ажил үйлчилгээний зардалд 13,911.1 сая төгрөгийг зарцуулж, 3,797.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 3,364.4 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж, Сангийн яамтай тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааг сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг харьяа байгууллагуудын онцлогт нийцүүлэн бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, аудитор Т.Баасанцэнд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд нь 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/878 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 704,217.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,042.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуваарилагдсан төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, хуульд тусгагдсан хэмнэлтийн горим, бусад арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход анхаарч ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

- Байгууллагын үйл ажиллагааг хэвлэл, мэдээлэл, видео контент хэлбэрээр сурталчилсан, тараах материал хэвлүүлсэн, спортын уралдаан тэмцээн зохион байгуулсан, амралтын газар сургалт зохион байгуулсан. /Монгол улсын хөгжлийн банк ХХК 124.4 сая төгрөг, ЭЗХЯ 50.0 сая төгрөг, ЗГХХГ 37.5 сая төгрөг/
- Албан тушаалын автомашин ашигласан. /ЭЗХЯ 34.9 сая төгрөг/
- Бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан. /ШУА 3.0 сая төгрөг/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 5 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван саяас төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27 удаагийн 320.2 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн. /Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн/
- Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, цалингаас бусад таван саяас дээш зарлагын 367.6 сая төгрөгийн 12 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй, орлогын 4,716.9 сая төгрөгийн 27 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн /Үндэсний шинжлэх ухаан технологийн сан/
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 1,762.9 сая төгрөгийн 76 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй. /ЭЗХЯ/
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 64 тушаал шийдвэрээс 1,439.9 сая төгрөгийн 53 тушаал шийдвэрийг мэдээлээгүй. Мөн цалингийн зардлаас бусад таван саяас төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний нийт 114 гүйлгээнээс 84.2 сая төгрөгийн 4 мэдээллийг мэдээлээгүй, 4,454.1 сая төгрөгийн 80 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг ил тодоор мэдээлэх нийт 73 мэдээллээс 2,804.2 сая төгрөгийн 62 мэдээллийг нийтэд ил тод мэдээлээгүй. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасны дагуу 70.7 сая төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй, 127.5 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасны дагуу 996.3 сая төгрөгийн орлогын 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 136.0 сая төгрөгийн зарлагын 7 мэдээллийг мэдээлээгүй, 34.2 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 15 шийдвэрийг мэдээлээгүй /Ди Би Эм ассет менежмент ХХК/
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван саяас төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 119 гүйлгээнээс 3,643.9 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож, 19,737.0 сая төгрөгийн 111 мэдээллийг мэдээлээгүй, зарлагын нийт 14 гүйлгээнээс 42.8 сая төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй, 212.7 сая төгрөгийн 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг ил тодоор мэдээлэх нийт 219.5 сая төгрөгийн 10 мэдээллийг мэдээлээгүй, мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг нийтэд ил тод мэдээлээгүй. /Ди Би Эм лизинг ХХК/
- Шилэн дансны цахим хуудаст 66 мэдээлэл байршуулахаас 34 мэдээллийг хугацаа хоцроож, 466.0 сая төгрөгийн 28 мэдээллийг байршуулаагүй /Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ/

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар бусад хууль тогтоомжийн нийцлийн зөрчлийг арилгаж, таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлж, давтан гаргахгүй байх 21 зөвлөмж өгсөн.

Түүврийн байгууллагууд

Илрүүлэлт 1: Үндэсний хөгжлийн хүрээлэн нь өмнөх аудитаар өгсөн "Албан хаагчдын цалингийн хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сан, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг баримталж тогтоох." зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” 69 дүгээр зүйлийн 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна”, гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, дээд шатны төсвийн захирагчид уламжлан албан хаагчдын цалингийн хэмжээг Монгол Улсын Засгийн газраас тогтоосон цалингийн жишгийг баримтлан тогтоох албан шаардлага хүргүүлээ.

Аудитын илрүүлэлт:

- Зардлын ангилал алдагдсан, үндсэн болон хөтөлбөрийн зардлыг холин төлөвлөсөн. /ҮШУТС/
- Хүчингүй жишиг баримт бичиг ашигласан, шаардлага хангаагүй оролцогч шалгаруулсан, ашиг сонирхлын мэдүүлэг дутуу бүрдүүлсэн. /ҮШУТС, ЭЗХЯ, ЗГХХГ/
- Хөрөнгийн бүртгэл, коджуулалтад тавих хяналт сул, тулгалт хийх боломжгүй. /ЗГХХГ/
- Төслийг сонгон шалгаруулах болон санхүүжилт олгох эрх зүйн зохицуулалт тодорхойгүй. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Шийдвэр гаргалт ТУЗ-д төвлөрч, гүйцэтгэх удирдлагын эрх мэдэл сул, засаглал, ил тод байдал хангалтгүй, удирдлагын томилгоо ил тод бус, хүний нөөцийн тогтворгүй байдал үүссэн. /Монгол улсын хөгжлийн банк ХХК, Ди Би Эм ассет/
- Төлөвлөлт бодит бус, зээл олголт хэрэгжээгүй, хэрэгжилт хангалтгүй, зээлийн багцын чанар муудаж, эрсдэлийн удирдлага сул. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Эх үүсвэрийн ашиглалт үр ашиггүй, бага хүүтэй байршуулсан. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Баталгааны үүрэг хангаагдаагүй байхад бүртгэлээс хассан. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Охин компанид тавих хяналт сул, Ди Би Эм ассет менежмент ХХК-ийн гүйцэтгэх захирал нь Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн Хөрөнгийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгчийн ажлыг давхар гүйцэтгэсэн. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Хэвлэл, контент, арга хэмжээнд үр ашиггүй зардал гаргасан. /Монгол улсын хөгжлийн банк ХХК/
- Зөвлөх үйлчилгээний гэрээг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт сул, ил тод байдлын мэдээллийг цахим хуудсанд байршуулж, тайлагнаагүй. /Ди Би Эм ассет менежмент ХХК, Ди Би Эм лизинг ХХК/
- Санхүүгийн тайланг хугацаанд нь аудитад ирүүлээгүй, Сангийн яамнаас нийтэд мэдээлсэн Нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад багтаагүй программ ашигласан. /ЗГХХГ/

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулан ажилласан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 1 албан шаардлага, 5 зөвлөмж, түүврийн байгууллагад хүргүүлсэн 1 албан шаардлага, өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд нийт биелэлт 90.9 хувьтай байна.

Хүснэгт 14. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төсвийн ерөнхийлөн захирагч						
1	Төлбөрийн акт	1	2,443.8	1	2,443.8	100.0
2	Зөвлөмж	4	-	4	-	100.0
Төрийн өмчит үйлдвэрийн газар						
1	Зөвлөмж	3	2.1	2	2.1	66.6
Төсвийн шууд захирагч						
1	Албан шаардлага	1	14.4	1	14.4	100.0
2	Зөвлөмж	2	3.0	2	3.0	100.0
Нийт дүн		11	2,466.3	10	2,466.3	90.9

Өмнөх аудитаар албан хаагчдын цалингийн хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сан, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг баримталж тогтоох зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ-т албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дараа жилийн аудитаар Боловсролын яамны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 02/5888 дугаар албан бичгээр ТӨБЗГ-т Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластерийн эхний үлдэгдлийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяанд шилжүүлэх талаар тогтоол гаргуулж, бүртгэсэн эсэхийг үзэх.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Монгол улсын засгийн газар Төрийн өмчит үйлдвэрийн газруудын цалингийн шатлалын жишиг бүдүүвчийг батлаагүйгээс МУТШСБЭЗХС харья төрийн өмчит үйлдвэрийн газрын цалинг өөрт олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн цалинг тогтоож байгаа асуудлыг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 1,465,704.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,309,752.8 сая төгрөгийн алдааг залруулж, 155,951.2 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

Монгол улсын хөгжлийн банк ХХК-ийн залруулаагүй алдаа:

- "ЗГҮЦ-ыг анх худалдан авсан үеийн бодит үнэ цэнээр хэмжсэн боловч дараа үеийн хэмжилт хийгээгүй;
- Банк өөрийн гаргасан өрийн хэрэглүүрийг худалдаж авсан ажил гүйлгээг СТОУС 9-н дагуу санхүүгийн өр төлбөрөөс хасаж бүртгэх ёстой байтал тусдаа хөрөнгөөр бүртгэсэн. Банк эдгээр үнэт цаасыг гаргагч/оролцогч талуудын зээлжих зэрэглэл 2024-2025 онд мэдэгдэхүйц буураагүй тул материаллаг үнэ цэнийн бууралтын сан байгуулаагүй байна.";
- ТОСК бондын эргэн төлөгдөх эх үүсвэрийн мөнгөн урсгал үнийн цэнийн бууралтыг үнэлэн 69.48 хувиар буюу 134,343.6 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулахаар тооцсон ч эрсдлийн санг байгуулаагүй;
- Шинэ яармаг төслийн дууссан болон дуусаагүй барилгуудын үнэлгээг 2022 болон 2023 онд тодорхойлсон Гантиг вилла төслийн үнэлгээг МУХБ-ны ЭУГ-ын хөрөнгийн үнэлгээний сургалтад хамрагдаж гэрчилгээ аваагүй мэргэжилтэн бэлтгэсэн;
- Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарсан 12 зээлийн хувьд шүүхийн шийдвэрт тусгасан барьцаа хөрөнгийн үнэлгээний дүнг эрсдэлийн сангийн тооцоололд ашигласан;
- Санхүүгийн тайланд тусгасан биет хөрөнгийн дүн тооллогын бүртгэлээс 154.5 сая төгрөгөөр биет бус хөрөнгийн дүн 88.6 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлэгдсэн.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг", НББОУС-1-ийн 15-т "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дээрх алдааг аудитын явцад залруулга хийгдсэн.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 34 байгууллагын тайлан нэгтгэснээс "Өөрчлөлтгүй" 11, "Хязгаарлалттай" 5, "Сөрөг" 1 санал дүгнэлт өгч, 17 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитаар 516,867.5 сая төгрөгийн 119 зөрчил илэрснээс 99.1 сая төгрөгийн зөрчилд 23 төлбөрийн акт тогтоож, 510,635.1 сая төгрөгийн зөрчилд 54 албан шаардлага хүргүүлж, 5,714.1 сая төгрөгийн зөрчилд 40 зөвлөмж, 419.2 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 672,818.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил² нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 665,776.5 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

5.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 672,818.7 сая төгрөгийн 121 зөрчил илэрснээс 99.1 сая төгрөгийн зөрчилд 23 төлбөрийн акт тогтоож, 510,635.1 сая төгрөгийн зөрчилд 52 албан шаардлага хүргүүлж, 161,665.3 сая төгрөгийн зөрчилд 44 зөвлөмж, 419.2 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага өгсөн байна. Энэ нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 666,183.8 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнг бууруулж ажиллах зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Өмнөх аудитаар Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн өмнөх захиралд тогтоосон 190/А0175303 дугаартай 24.3 сая төгрөгийн төлбөрийн актаас 5.6 сая төгрөгийг барагдуулж, шийдвэрийн хэрэгжилт 22.9 хувь буюу хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн захиралд тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, төлбөрийн актыг бүрэн барагдуулах арга хэмжээг авч ажиллах, албан шаардлага хүргүүлээ.

5.1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шинжлэх ухааны салбарын харьяа хүрээлэнгүүд нь Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/113 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглахаар байгаа боловч тус хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны онцлогт таарахгүй байгаа тул Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана." 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрсдийн дотоод нөөцийг ашиглан нэмэлт зардал гаргахгүйгээр Шинжлэх ухааны салбарын харьяа хүрээлэнгүүдийн онцлогт нийцүүлэн бэлтгэх.

5.2 Түүврийн байгууллагын аудитаар илэрсэн алдаа, зөрчил:

5.2.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захиралтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Ээлжийн амралтын 8.6 сая төгрөгийн олговортой давхардуулан 5.1 сая төгрөгийн цалин хөлс олгосон;
- Шатахууны зарцуулалтыг өдрийн 40 км-ээр тооцож нийт 2.7 сая төгрөгийн шатахууныг хувийн автомашиндаа хэрэглэж зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 8-д "Энэ тогтоолын хавсралтад заасан суудлын автомашиныг өдрийн 60 км, дуудлага үйлчилгээний автомашиныг өдрийн 40 км-ээс хэтрүүлэхгүйгээр ашиглаж байхаар тогтоосугай." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалин, хөлсийг зөрүүтэй тооцож олгосон, хувийн автомашинд байгууллагын шатахууныг зарцуулсан зөрчилд 7.8 сая төгрөгийг төсөв төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Үндэсний хөгжлийн хүрээлэн нь төсвийн төсөлд тусгагдаж, тайлант оны төсөвт батлагдаагүй нийт 159.0 сая төгрөгийн цалин хөлс олгосон зөрчил илэрсэн. Үүнд:

- Хүрээлэнгийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар ур чадварын нэмэгдэлийн хэмжээг батлан, 29.7 сая төгрөгийн нэмэгдэл олгосон;
- Орон тооны бус эрдмийн зөвлөлийн урамшууллын хэмжээг Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд Бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 тоот тушаалаар эрдмийн зөвлөлийн даргад 3.0 сая төгрөг, эрдмийн зөвлөлийн гишүүнд 1.5 сая төгрөг байхаар тогтоосон боловч тайлант онд 2 удаа хуралдаж, хүрээлэнгийн захирал эрдмийн зөвлөлийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсөнд сар бүр 3.0 сая төгрөг, эрдмийн зөвлөлийн 6 гишүүнд сар бүр 1.5 сая төгрөг, нийт 129.3 сая төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 22 дугаар зүйлийн 22.2.3-т "эдийн засгийн ангиллаар,"; 22.2.4-т "хөтөлбөрөөр", 22.2.5-д "арга хэмжээгээр,"; 22.6.7-д "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх" мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсөвт тусгагдаагүй цалин, хөлс олгодог зөрчлийг таслан зогсоож, төсвийн төслийн саналыг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 2: Үндэсний хөгжлийн хүрээлэн нь томилолтын тушаал шийдвэргүйгээр байгууллагын ажилтны автомашинд 6 удаа нийт 1.6 сая төгрөгийн шатахуун олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын тушаал шийдвэргүйгээр байгууллагын ажилтны автомашинд шатахуун олгодог зөрчлийг таслан зогсоож, албан томилолтоор ажиллахдаа улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр үйлчлүүлж байх албан шаардлага хүргүүлээ.

Илрүүлэлт 3: Шинжлэх ухааны паркийн захиргаа нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан ахлах нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр 1.9 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус хүрээлэнгийн санхүүгийн албан хаагчид үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
								Залруулсан		Залруулаагүй				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төрийн өмчит үйлдвэрийн газар														
1	Монгол улсын хөгжлийн банк ХХК	9	1,449,295.4		-		-	4	1,293,344.2			5	155,951.2	
2	Ди Би Эм лизинг ХХК	9	10,253.0	1	0.03	-	10,252.9	1	10,253.0				-	
3	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ	4	80.2	1	0.3	3	79.9	4	80.2				-	
Дүн		22	1,459,628.6	2	0.33	3	10,332.9	9	1,303,677.5			5	155,951.2	
Төсвийн шууд захирагч														
1	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар	6	3,136.5	2	2,381.3	4	755.2	6	3,136.5					
2	Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн	1	1,232.4	-	-	1	1,232.4	1	1,232.4					
3	Эдийн засаг, хөгжлийн яам	2	919.6	1	6.4	1	913.2	2	919.6					
4	Газарзүй, геоэкологийн хүрээлэн	2	706.1	-	-	2	706.1	2	706.1					
5	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	7	62.2	1	6.7	6	55.5	7	62.2					
6	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	5	13.3	1	3.9	4	9.4	5	13.3					
7	Физик технологийн хүрээлэн	2	5.2		-	2	5.2	2	5.2					
Дүн		25	6,075.3	5	2,398.3	20	3,677.0	25	6,075.3					
Нийт дүн		47	1,465,704.0	7	2,398.6	23	14,009.9	34	1,309,752.8			5	155,951.2	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч													
1	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	3	-			2	-	1	-				
	Дүн	3	-			2	-	1	-				
Төсвийн төвлөрүүлэн захирагч													
1	Шинжлэх ухааны академи	3	54.6			3	54.6						
2	Үндэсний шинжлэх ухаан технологийн сангийн ажлын албаны дарга	1	-					1	-				
	Дүн	4	54.6			3	54.6	1	-				
Төрийн өмчит үйлдвэрийн газар													
1	Монгол улсын хөгжлийн банк ХХК	14	494,799.1	5	37.6	5	490,636.8	4	4,124.7				
2	Ди Би Эм лизинг ХХК	8	16,905.9	4	12.5	1	16,878.5	3	14.9				
3	Ди Би Эм ассет менежмент ХХК	8	343.4	2	6.3	4	204.3	2	132.8				
4	Үндэсний хөгжлийн хүрээлэн	3	168.4	1	7.8	2	160.6						
5	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ	5	91.9	1	8.6	2	21.0	2	62.3				
	Дүн	38	512,303.6	13	67.7	14	507,901.2	11	4,334.7				
Засгийн газрын тусгай сан													
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	6	481.6			2	461.7	4	19.9				
	Дүн	6	481.6			2	461.7	4	19.9				
Төсвийн шууд захирагч													
1	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар	20	2,555.0	2	18.9	10	1,219.9	6	896.9	2	419.2	1	94.6
2	Эдийн засаг, хөгжлийн яам	14	813.3	1	2.6	9	754.6	4	56.0			1	280.5
3	Физик технологийн хүрээлэн	1	216.7					1	216.7				
4	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн	1	123.0					1	123.0				
5	Археологийн хүрээлэн	1	87.6			1	87.6						
6	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	8	59.0	2	5.1	3	35.8	3	18.2				
7	Биологийн хүрээлэн	4	43.2	1	2.0	1	40.3	2	0.9				
8	Палентологийн хүрээлэн	1	35.0			1	35.0						
9	Ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний хүрээлэн	2	33.9					2	33.9				
10	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	4	23.3	2	0.8	1	17.6	1	4.9				

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

11	Олон улс судлалын хүрээлэн	1	19.1			1	19.1						
12	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	2	7.5	1	1.8			1	5.7				
13	Хими химийн технологийн хүрээлэн	4	5.7			4	5.7						
14	Одон орон геофизикийн хүрээлэн	1	2.0					1	2.0				
15	Шинжлэх ухааны паркийн захиргаа	1	1.9			1	1.9						
16	Газарзүй геозкэологийн хүрээлэн	2	1.3			1		1	1.3				
17	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	1	0.1	1	0.1								
Дүн		68	4,027.8	10	31.4	33	2,217.7	23	1,359.5	2	419.2	2	375.1
Нийт дүн		119	516,867.5	23	99.1	54	510,635.1	40	5,714.1	2	419.2	2	375.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Засгийн газрын тусгай сан											
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	1	367.6			1	367.6				
	Дүн	1	367.6			1	367.6				
Төсвийн шууд захирагч											
1	Ди Би Эм лизинг ХХК	1	23,855.9			1	23,855.9				
2	ХБ	1	9,054.6			1	9,054.6				
3	Эдийн засаг, хөгжлийн яам	1	1,762.9			1	1,762.9				
4	Ди Би Эм ассет менежмент ХХК	1	1,364.7					1	1,364.7		
5	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ	1	466.0							1	466.0
6	Уламжлалт анагаах ухаан	1	320.2			1	320.2				
	Дүн	6	36,824.3			4	34,993.6	1	1,364.7	1	466.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Төрийн өмчит үйлдвэрийн газар											
1	Монгол улсын хөгжлийн банк ХХК	15	550,404.6			7	550,212.7	8	191.9		
2	Ди Би Эм ассет менежмент ХХК	5	-					5	-		
3	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ	4	-					4	-		
4	Үндэсний хөгжлийн хүрээлэн	1	-			1	-				
	Дүн	25	550,404.6			8	550,212.7	17	191.9		
Засгийн газрын тусгай сан											
1	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	3	-					3	-		
	Дүн	3	-					3	-		
Төсвийн шууд захирагч											
1	Эдийн засаг, хөгжлийн яам	1	-					1	-		
10	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар	2	-					2	-		
	Дүн	3	-					3	-	-	-
	Нийт дүн	38	587,596.5			13	585,573.9	24	1,556.6	1	466.0

Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Санал хэлбэр	Аудит хийсэн байгууллагын нэр
1	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	Хязгаарлалттай	Үндэсний аудитын газар
2	Шинжлэх ухааны академи	Өөрчлөлтгүй	Үндэсний аудитын газар
3	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга	Хязгаарлалттай	Үндэсний аудитын газар
4	Монгол улсын хөгжлийн банк ХХК	Сөрөг	Үндэсний аудитын газар
5	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ	Хязгаарлалттай	Үндэсний аудитын газар
6	Ди Би Эм ассет менежмент	Хязгаарлалттай	Үндэсний аудитын газар
7	Ди Би Эм лизинг	Хязгаарлалттай	Үндэсний аудитын газар
8	Хими, химийн технологийн хүрээлэн	Өөрчлөлтгүй	Гроут Финанс Аудит ХХК
9	Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн	Өөрчлөлтгүй	Төгсгүүд консалтинг аудит ХХК
10	Газарзүй, гео-экологийн хүрээлэн	Өөрчлөлтгүй	Төгсгүүд консалтинг аудит ХХК
11	Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн	Өөрчлөлтгүй	Төгсгүүд консалтинг аудит ХХК
12	Одон орон, геофизикийн хүрээлэн	Өөрчлөлтгүй	Анализ старт аудит ХХК
13	Оюуны өмчийн газар	Өөрчлөлтгүй	Төгсгүүд консалтинг аудит ХХК
14	Биологийн хүрээлэн	Өөрчлөлтгүй	Ажу мэргэн Аудит ХХК
15	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн	Өөрчлөлтгүй	Мишээл Од Аудит ХХК
16	ФИЗИК ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	Өөрчлөлтгүй	Анализ старт аудит ХХК
17	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн	Өөрчлөлтгүй	Их Наяд Аудит ХХК
18	Эдийн засаг, хөгжлийн яамны аппарат	Хязгаарлалттай	Үндэсний аудитын газар
19	Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар	Хязгаарлалттай	Үндэсний аудитын газар
20	Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
21	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
22	АНАГААХ УХААНЫ ХҮРЭЭЛЭН	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
23	Археологийн хүрээлэн	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
24	Геологийн хүрээлэн	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
25	МААЭШХҮРЭЭЛЭН	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
26	Математик, тоон технологийн хүрээлэн	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
27	ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
28	Палеонтологийн хүрээлэн	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
29	Тархи, сэтгэл судлалын хүрээлэн	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
30	Технологийн инкубатор	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
31	Түүх угсаатны зүйн хүрээлэн	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
32	ФИЛИОСОФИ СОЦИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
33	ШУА-Тэргүүлэгчдийн газар	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
34	ШУА-ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
35	Шинжлэх ухааны паркийн захиргаа	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар
36	Шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт, их засвар, техник хяналт, барьцаа	Түүвэрт хамруулах	Үндэсний аудитын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1328/A0111371

Улаанбаатар хот

САГ-2026/31/КА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн өмнөх захиралд тогтоосон 190/A0175303 дугаартай 24,333,282.00 /Хорин дөрвөн сая гурван зуун гучин гурван мянга хоёр зуун наян хоёр/ төгрөгийн төлбөрийн актаас 5,570,952.00 /Таван сая таван зуун далан мянга есөн зуун тавин хоёр/ төгрөгийг барагдуулж, шийдвэрийн хэрэгжилт 22.9 хувь буюу хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "Төрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн сан хүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн захиралд тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, төлбөрийн актыг бүрэн барагдуулах арга хэмжээг авч ажиллах, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд /Ж.Энхбаяр/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Түвшинжаргал/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1327/А0111371

Улаанбаатар хот

САГ - 2026/31/КА - СТА - ТЕЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 672,818,650,400.00 /Зургаан зуун далан хоёр тэрбум найман зуун арван найман сая зургаан зуун тавин мянга дөрвөн зуу/ төгрөгийн 121 зөрчил илэрснээс 99,106,200.00 /Ерэн есөн сая нэг зуун зургаан мянга хоёр зуу/ төгрөгийн зөрчилд 23 төлбөрийн акт тогтоож, 510,635,062,600.00 /Таван зуун арван тэрбум зургаан зуун гучин таван сая жаран хоёр мянга зургаан зуу/ төгрөгийн зөрчилд 52 албан шаардлага хүргүүлж, 161,665,267,600.00 /Нэг зуун жаран нэгэн тэрбум зургаан зуун жаран таван сая хоёр зуун жаран долоон мянга зургаан зуу/ төгрөгийн зөрчилд 44 зөвлөмж, 419,214,000.00 /Дөрвөн зуун арван есөн сая хоёр зуун арван дөрвөн мянга/ төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 2 албан шаардлага өгсөн байна. Энэ нь өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлөөс 666,183,750,400.00 /Зургаан зуун жаран зургаан тэрбум нэг зуун наян гурван сая долоон зуун тавин мянга дөрвөн зуу/ төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнг бууруулж ажиллах зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, дотоод хяналтыг сайжруулах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban Shaardlaga 2026-0424 SAG-60.Docx

1526182444

2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд /Ж.Энхбаяр/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Түвшинжаргал/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



СМ

С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1326/A0170039

Улаанбаатар хот

САГ - 2026/317/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухааны паркийн захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан ахлах нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр 1,948,750.00 /Нэг сая есөн зуун дөчин найман мянга долоон зуун тавин/ төгрөгийн урамшуулал олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т "Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тус хүрээлэнгийн санхүүгийн албан хаагчид үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын урамшуулал олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухааны паркийн захиргааны гүйцэтгэх захирал /Н.Тэгшбаяр/, ахлах нягтлан бодогч /Г.Ганжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga-2026/0424 SAG-20.Docx

1526182150



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1325/A0170039

Улаанбаатар хот

САГ-2026/75/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн "Албан хаагчдын цалингийн хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сан, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг баримталж тогтоох." зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Энэ нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 69 дүгээр зүйлийн 69.3-т "Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, дээд шатны төсвийн захирагчид уламжлан албан хаагчдын цалингийн хэмжээг Монгол Улсын Засгийн газраас тогтоосон цалингийн жишгийг баримтлан тогтоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал /Г.Дэнзэн/, ахлах нягтлан бодогч /О.Алтанцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1324/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/75/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтын тушаал шийдвэргүйгээр байгууллагын ажилтны автомашинд 6 удаа нийт 1,554,156.00 /Нэг сая таван зуун тавин дөрвөн мянга нэг зуун тавин зургаан/ төгрөгийн шатахуун олгосон байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Томилолтын тушаал шийдвэргүйгээр байгууллагын ажилтны автомашинд шатахуун олгодог зөрчлийг таслан зогсоож, албан томилолтоор ажиллахдаа улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн хэрэгслээр үйлчлүүлж байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал /Г.Дэнзэн/, ахлах нягтлан бодогч /О.Алтанцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1323/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/75/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төсөлд тусгаж, тайлант оны төсөвт батлагдаагүй нийт 159,000,000.00 /Нэг зуун тавин есөн сая/ төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Хүрээлэнгийн захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар ур чадварын нэмэгдлийн хэмжээг батлан, 29,700,000.00 /Хорин есөн сая долоон зуун мянган/ төгрөгийн нэмэгдэл олгосон;
- Орон тооны бус эрдмийн зөвлөлийн урамшууллын хэмжээг Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд Бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 тоот тушаалаар эрдмийн зөвлөлийн даргад 3,000,000.00 /Гурван сая/ төгрөг, эрдмийн зөвлөлийн гишүүнд 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган/ байхаар тогтоосон боловч тайлант онд 2 удаа хуралдаж, хүрээлэнгийн захирал эрдмийн зөвлөлийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсөнд сар бүр 3,000,000.00 /Гурван сая/ төгрөг, эрдмийн зөвлөлийн 6 гишүүнд сар бүр 1,500,000.00 /Нэг сая таван зуун мянган/ төгрөг, нийт 129,300,000.00 /Нэг зуун хорин есөн сая гурван зуун мянган/ төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.2.3-т "эдийн засгийн ангиллаар;" 22.2.4-т "хөтөлбөрөөр", 22.2.5-д "арга хэмжээгээр;" 22.6.7-д "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 4.1.6-д "сахилга баттай байх", 4.1.9-д "хариуцлагатай байх" 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талээр байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban Shaardlaga\2026\0424 SAG-20.Docx

1526182144

1. Батлагдсан төсөвт тусгагдаагүй цалин, хөлс олгодог зөрчлийг таслан зогсоож, төсвийн төслийн саналыг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал /Г.Дэнзэн/, ахлах нягтлан бодогч /О.Алтанцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
АУДИТОР



Д.БАЯРСАЙХАН
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.БААСАНЦЭНД
Г.ТЭЛМҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 232/А0170039

Улаанбаатар хот

САГ-2026/75/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус хүрээлэнгийн захиралтай холбоо дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Ээлжийн амралтын 8,637,600.00 /Найман сая зургаан зуун гучин долоон мянга зургаан зуун/ төгрөгийн олговортой давхардуулан 5,176,000.00 /Таван сая нэг зуун далан зургаан мянган/ төгрөгийн цалин хөлс олгосон;
- Шатахууны зарцуулалтыг өдрийн 40 км-ээр тооцож нийт 2,680,000.00 /Хоёр сая зургаан зуун наян мянган/ төгрөгийн шатахууныг хувийн автомашиндаа хэрэглэж зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "үнэн зөв байх," 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянаж, баталгаажуулах," Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Монгол улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 8-д "Энэ тогтоолын хавсралтад заасан суудлын автомашиныг өдрийн 60 км, дуудлага үйлчилгээний автомашиныг өдрийн 40 км-ээс хэтрүүлэхгүйгээр ашиглаж байхаар тогтоосугай." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон," гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалин, хөлсийг зөрүүтэй тооцож олгосон, хувийн автомашинд байгууллагын шатахууныг зарцуулсан зөрчилд 7,776,000.00 /Долоон сая долоон зуун далан зургаан мянган/ төгрөгийг Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирал Г.Дэнзэнгээр төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

